

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлийг үндэслэн нэг талаас Монгол улсын Засгийн газрыг төлөөлж Монгол улсын Сангийн сайд (цаашид "Сайд" гэнэ), нөгөө талаас тогтвортой байдлын тухай гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан, Монгол улсад үүсгэн байгуулагдсан, 21/498 тоот бүртгэлийн гэрчилгээтэй, ашигт малтмал ашиглах А-32 дугаарын лицензи эзэмшигч Монгол-Их Британы хамтарсан ~~Бороогийн~~ Компани (цаашид "Компани" гэнэ)-тай үйл ажиллагаагаа явуулах орчныг нь урт хугацаанд тогтвортой байлгах баталгаа болгож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр зохицуулах зүйл

- 1.1 Энэ гэрээгээр Компани Монгол улсын Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутагт орших Бороогийн алтны ордыг үйлдвэрлэлийн аргаар эзэмших, ашиглах төслийг хэрэгжүүлэх хугацаанд татварын тогтвортой нөхцлийг хангах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлийн үнээр чөлөөтэй борлуулах, экспортлох, үүнээс олсон чөлөөт валютын орлогоо захиран зарцуулах эрхийн баталгаагаар хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Үндсэн нөхцөл

- 2.1 Ашигт малтмал ашиглах лицензи эзэмшигч Компанийн Монгол улсын нутаг дэвсгэрт тухайн төслийн эхний 5 жилд оруулах анхны хөрөнгө оруулалтын хэмжээ арван тав (15)-ан сая ам.доллараас багагүй байна.
- 2.2 Компанийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг үйлдвэрлэл явуулж эхлэснээс хойшхи эхний гурав (3)-ан жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн гурав (3)-ан жилд тавин (50) хувиар хөнгөлнө. Үүнээс цаашхи хугацааны жилийн татвар ногдох орлого нь нэг зуу (100)-н сая төгрөгөөс доош бол арван тав (15)-ан хувь, нэг зуу (100)-н сая төгрөгөөс дээш бол дөч (40)-ин хувь, импортын барааны гаалийн татварыг тэг (0) хувь, импортын болон дотоодод борлуулсан барааны нэмэгдсэн өртгийн албан татварыг арав (10)-ан хувь буюу энэхүү гэрээг хүчин төгөлдөр болох өдөр үйлчилж буй хууль тогтоомжид заасан хувь хэмжээнд байлгана.
- 2.3 Компани үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлоход экспортын татвар тэг (0) хувь, нэмэгдсэн өртгийн албан татварыг тэг (0) хувиар ногдуулна. Хэрэв Компани нь алт олборлож Монголбанк эсвэл Монгол улсын нутаг дэвсгэр дээрхи арилжааны аль нэг банкинд борлуулсан бол арав (10)-ан хувийн нэмэгдсэн өртгийн албан татварыг төлнө.
- 2.4 Компанийн төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа ашигт малтмалын холбогдолтой харилцааг зохицуулж буй хуульд заасан

хэмжээгээр тооцно.

- 2.5 Компани үйдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж, олон улсын зах зээлийн үнээр борлуулах, үүнээс олсон чөлөөт валютын орлогоо захиран зарцуулахад нь энэ талаар Монгол улсын иргэн, хуулийн этгээдэд олгодогтой адил эрх, нөхцлөөр хангана.
- 2.6 Компани нь энэхүү гэрээний 4.2, 4.3-д заасан хэмжээ, хугацаанд хөрөнгө оруулахаар хүлээсэн үүргээ биелүүлэлгүй (зургаа) 6 сар хэтрүүлсэн тохиолдолд энэхүү гэрээ хүчингүй болсонд тооцогдоно.

Гурав. Гэрээний хугацаа

- 3.1 Гэрээг 1998 оны 7 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн 2000 оны 7 дугаар сарын 7-ны өдрийг хүртэл арав (10)-ан жилийн хугацаагаар байгуулав.

Дөрөв. Компанийн эрх, үүрэг.

- 4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 4.2 Компани нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш тав (5)-ан хугацаанд арван тав (15)-ан сая ам. доллараас багагүй хөрөнгө оруулалт хийнэ.

Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, технологи, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материалаар хийж болно.

- 4.3 Хөрөнгө оруулалтыг дараах хуваарийн дагуу хийнэ:

|   | Он, сар                  | Мөнгөний дүн<br>(мянган ам.дол.) | Мөнгөн хэлбэрээр | Бусад<br>хэлбэрээр |
|---|--------------------------|----------------------------------|------------------|--------------------|
| 1 | 1999 оны 7<br>дугаар сар | 1,000                            | 500              | 500                |
| 2 | 2000 оны 7<br>дугаар сар | 14,000                           | 4,000            | 10,000             |
| 3 |                          |                                  |                  |                    |
| 4 |                          |                                  |                  |                    |
| 5 |                          |                                  |                  |                    |
|   |                          | 15,000                           | 4,500            | 10,500             |

Компани тухайн жилд төлөвлөснөөс илүү хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд давсан хэсгийг дараагийн жилийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд оруулж тооцно.

- 4.4 Компани нь тухайн жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайланг энэхүү гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хойш жил бүр тухайн жилийн дараагийн сард багтаан Сангийн яамнаас баталсан

маягтын дагуу гаргаж, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраар хянуулан Сангийн сайдад ирүүлж байна.

- 4.5 Компани нь бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогоо Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж буй аль нэг арилжааны банкинд нээсэн дансанд эхлэн байршуулна.
- 4.6 Сайд энэхүү гэрээгээр хариуцсан үүргээ биелүүлээгүйн улмаас Тогтвортой байдлын гэрээний баталгаа алдагдсан тохиолдолд баталгааг сэргээлгэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуульд заасан журмын дагуу нэхэмжлэх эрх эдлэнэ.
- 4.7 Энэхүү гэрээг байгуулснаар Монгол улсын Засгийн газрын холбогдох нэгжүүдтэй Бороогийн алтны ордын асуудлаар бусад гэрээ хэлэлцээ байгуулах Компанийн эрх нь ямар нэгэн хэлбэрээр хязгаарлагдахгүй болно.

#### 5. Сайдын үүрэг, эрх

- 5.1. Компани үйл ажиллагаагаа явуулах орчныг нь урт хугацаанд тогтвортой байлгах талаар энэхүү гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хангах явдлыг хариуцна.
- 5.2. Тогтвортой байдлын гэрээнд гарын үсэг зурсны дараа уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг Монголбанк болон холбогдох газруудад хүргүүлнэ.
- 5.3. Компани нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл Монгол Улсын хххуулийг ноцтой зөрчсөн нь нотлогдвол Сайд энэ тухай Компанид албан мэдэгдэл өгч гэрээг дангаар цуцална.


#### 6. Бусад зүйл

- 6.1. Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон ямар нэгэн маргаантай асуудал үүсвэл талууд аль болох хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ. Нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль болон олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.
- 6.2. Гэрээг 1998 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хотод монгол, англи хэл дээр тус бүр хоёр (2) хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалав.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

САНГИЙН САЙД

Б.БАТБАЯР



ЭХ СУРВАЛЖ: [WWW.ILTODGEREE.MN](http://WWW.ILTODGEREE.MN)

## ТОГВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

Тогтвортой байдлын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай энэхүү Гэрээг нэг талаас Монгол улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд (Сангийн сайд), нөгөө талаас Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, 21/498 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй Бороо Гоулд ХХК (Компани) харилцан тохиролцож байгуулав.


### ОРШИЛ

- A. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлийг үндэслэн Бороогийн алтны төсөл (Төсөл)-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай урт хугацааны тогтвортой байдлыг бий болгох зорилгоор Сангийн сайд болон Компани нь 1998 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Тогтвортой байдлын гэрээ (Тогтвортой байдлын гэрээ)-г байгуулсан.
- B. Тогтвортой байдлын гэрээнд гарын үсэг зурснаас хойших хугацаанд Компани нь нэмэлт өрөмдлөг, үнэлгээ хийх, төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад 4.5 сая ам.доллар зарцуулж, Төслийн хэрэгжилтийг урагшлуулах үйл хэрэгт ахиц гаргасан байна.
- C. Төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хянан үзсэний дүнд Компани нь Төслийн хэрэгжилтийн эхний 5 жилд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг 15 сая ам.доллараас 25 сая ам.доллар, Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээг 20 сая ам.доллараас 30 сая ам.доллар болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн зэргийг харгалзан үзэж,

### ХЭЛЭЛЦЭН ТОХИРСОН нь:

Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнийг Тогтвортой байдлын гэрээнд тусгаж, уг гэрээний зарим заалтыг тодруулах зорилгоор Тогтвортой байдлын гэрээнд дараахь нэмэлт, өөрчлөлт оруулахыг Сангийн сайд болон Компани нь үүгээр харилцан тохиролцож байна. Үүнд:

1. Тогтвортой байдлын гэрээний 2.1 болон 4.2 дахь заалтад "арван таван (15) сая ам.доллар" гэснийг "хорин таван (25) сая ам.доллар" гэж тус тус өөрчлөх;
2. Тогтвортой байдлын гэрээний 3.1 дахь заалтад "2008 оны 7 дугаар сарын 7 хүртэл арван (10) жилийн хугацаанд" гэснийг "2013 оны 7 дугаар сарын 7 хүртэл арван таван (15) жилийн хугацаанд" гэж өөрчлөх;



ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN



3. Тогтвортой байдлын гэрээний 4.3 дахь заалтад заасан хөрөнгө оруулалтын хуваарийг дараахь хуваариар солих:

| Дугаар | Он сар                | Хөрөнгө оруулалтын хэмжээ (мянган ам.д.) | Мөнгөн хэлбэрээр | Бусад хэлбэрээр |
|--------|-----------------------|------------------------------------------|------------------|-----------------|
| 1      | 1999 оны 7 дугаар сар | 1,000                                    | 500              | 500             |
| 2      | 2000 оны 7 дугаар сар | 5,000                                    | 2,000            | 3,000           |
| 3      | 2001 оны 7 дугаар сар | 15,000                                   | 5,000            | 10,000          |
| 4      | 2002 оны 7 дугаар сар | 2,000                                    | 1,000            | 1,000           |
| 5      | 2003 оны 7 дугаар сар | 2,000                                    | 1,000            | 1,000           |
|        | Нийт дүн:             | 25,000                                   | 9,500            | 15,500          |

4. Тогтвортой байдлын гэрээний монгол эх бичвэрийн 2.2 дахь заалтын хоёр дахь өгүүлбэр нь найруулгын хувьд буруу ойлголт төрүүлж болзошгүй байдлыг арилгахын тулд уг өгүүлбэр дахь "... /40/-ин хувь..." гэсний дараахь таслалыг цэг болгох (англи эх бичвэрт өөрчлөлт орохгүй).
5. Тогтвортой байдлын гэрээний 2.2 дахь заалтын эцэст дараахь өгүүлбэр нэмнэ. Үүнд:
- "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол улсын хуулийн 11 зүйлд заасанчлан, Компани нь төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвараа бусад бүх төрлийн албан татвараас хасаж тооцож болохыг Сангийн сайд үүгээр нотолж байна".
6. Тогтвортой байдлын гэрээний 2.3 дахь заалтын эцэст дараахь өгүүлбэр нэмнэ. Үүнд:
- "Төслийг хэрэгжүүлэх хугацаанд Компани нь олборлосон алтаа чөлөөтэй экспортолж болохыг Сангийн сайд үүгээр нотолж байна. Компани нь алт экспортлох асуудлаар Монголбанктай тусгайлан гэрээ байгуулж ажиллана".
7. Тогтвортой байдлын гэрээний 2.4 дэх заалтын эцэст дараахь өгүүлбэрийг нэмнэ. Үүнд:
- "Тэр нь бүтээгдхүүний борлуулалтын 2.5 хувьтай тэнцэнэ".
8. Тогтвортой байдлын гэрээнд шинээр 2.7 дахь заалтыг нэмж оруулах:
- "2.7 Төсөл болон Төсөлтэй холбоотойгоор Компани, түүний гэрээлэгчдийн эзэмшиж, ашиглаж буй аливаа өмч, хөрөнгө, лицензи, эзэмших эрхийг Монгол улсын Засгийн газар нийгэмчлэхгүй, дайчлан гаргуулахгүй буюу хууль бусаар хураан авахгүй".
9. Тогтвортой байдлын гэрээнд шинээр 2.8 дахь заалтыг нэмж оруулах:

"2.8 Компани нь гагцхүү энэхүү гэрээг байгуулах үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулийн дагуу албан татварыг энэ гэрээнд заасан хэмжээгээр, хэрэв татварын төрөл болон хэмжээг нь заагаагүй бол гэрээг байгуулах үед үйлчилж байсан хэмжээгээр төлнө гэдгийг Сангийн сайд үүгээр нотолж байна. Хэрэв энэхүү Гэрээг байгуулснаас хойш Компанийн хувьд илүү таатай дэглэм тогтоосон аливаа хууль тогтоомж батлагдвал, Компани нь тухайн таатай дэглэмийг эдлэх хүсэлтээ Сангийн сайдад бичгээр гаргаж болно".

10. Тогтвортой байдлын гэрээний 4.5 дахь заалтын эцэст дараахь өгүүлбэрийг нэмж оруулах:

"Энэ зүйлд нийцүүлэх зорилгоор Компани нь тэрхүү дансанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, энэхүү Гэрээний зохих заалтуудын дагуу төлөх ёстой бүх төрлийн татвар зэрэг Монгол улсын Засгийн газрын өмнө хүлээхээр төлөвлөсөн сар бүрийн санхүү, татварын үүргээ гүйцэтгэхэд хангалттай хэмжээний мөнгөн хөрөнгийг сар тутам шилжүүлнэ. Үлдсэн мөнгөн хөрөнгийг Компани нь өөрийн гадаад дахь дансандаа хадгалж, чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байна."

11. Тогтвортой байдлын гэрээний 5.3 дахь заалтын эцэст дараахь өгүүлбэрүүдийг нэмж оруулах:

"Гэхдээ Сангийн сайд нь энэхүү зөрчлийн талаар Компанид бичгээр мэдэгдэнэ. Компани мэдэгдэл авснаас хойш 120 хоногийн дотор зөрчлийг арилгана. Сангийн сайд дангаараа энэ гэрээг дор дурьдсан тохиолдолд цуцлаж болохгүй. Үүнд:

- (a) Компани 120 хоногийн дотор зөрчлийг Сангийн сайдын шаардлагыг хангахуйц хэмжээнд арилгасан;
- (b) зөрчлийг 120 хоногийн дотор арилгах боломжгүй бол Компани нь тэрхүү зөрчилтэй холбогдуулан Сангийн сайдын шаардлагыг хангахуйц хэмжээнд зохих нөхөн төлбөрийг төлөх саналыг Засгийн газарт албан ёсоор тавьсан эдгээр болно."

12. Тогтвортой байдлын гэрээний 6.1 дэх заалтын эцэст дараахь өгүүлбэрүүдийг нэмж оруулах:

"Тухайлбал, ийнхүү шийдвэрлэж чадаагүй аливаа маргааныг Улс ба бусад улсын иргэд, хуулийн этгээд хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг таслах тухай Конвенци (Конвенци)-ийн дагуу арбитраар шийдвэрлүүлэхээ талууд үүгээр зөвшөөрч, арбитраар шүүхийн хурлыг Нью-Йорк хотноо хуралдуулах болно. Конвенцийн 25(2) дугаар зүйлийн (b)-д нийцүүлж Компанийг Их Британы харьяалалтай гэж үзнэ."

Конвенцийн дагуу арбитраас гарсан аливаа тогтоол, шийдвэр (үүнд хэрэг хянан шийдвэрлэх явцад гарсан тогтоол, шийдвэр хамаарна) нь талуудын хувьд заавал биелэгдэх хуулийн хүчинтэй бөгөөд тэдгээрийг дотоодын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлж болно. Энэхүү заалтад дурьдсан "маргаан" гэдэг нь Тогтвортой байдлын гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулсан байдлаар) ба Төсөлтэй, түүнчлэн тэдгээрийг зөрчих, цуцлах, хүчинтэй эсэх асуудалтай холбогдон үүссэн бөгөөд талуудын харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэж чадаагүй аливаа маргаан, гомдлын шаардлага, саналын зөрүүг хэлнэ."

13. Тогтвортой байдлын гэрээнд шинээр 6.2 дахь заалтыг нэмж оруулах:

"Энэхүү Гэрээг Монгол улсын хууль (хэм хэмжээний зөрчилдөөнийг зохицуулах тухай заалтуудын хамт)-иар, зохицуулан тайлбарлана. Түүнчлэн, хэм хэмжээний зөрчилдөөнийг зохицуулахдаа олон улсын хэм хэмжээг хэрэглэж болно."

14. Тогтвортой байдлын гэрээний одоо байгаа 6.2 дахь заалтыг 6.3 дахь заалт болгож түүний эцэст дараахь өгүүлбэрийг нэмж оруулах. Үүнд:


"Тогтвортой байдлын гэрээ (нэмэлт, өөрчлөлт хийсэн байдлаар)-г тайлбарлахтай холбогдон аливаа маргаан үүссэн тохиолдолд англи эх бичвэр нь шийдвэрлэгч байна".

Энэхүү Гэрээ нь Тогтвортой байдлын гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнтэй хамт хэрэглэгдэнэ.

Энэхүү Гэрээг 2000 оны 5 дугаар сарын 9 -ний өдөр Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо монгол, англи хэл дээр 2 хувь үйлдэж тал тус бүр нэг нэг хувийг хадгалав.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

САНГИЙН САЙД

  
Я. ОЧИРСҮХ

БОРОО ГОУЛД КОМПАНИЙГ  
ТӨЛӨӨЛЖ

ЗАХИРАЛ



  
Ж. ЖОУНС